



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ

2017 оны 05 сарын 12 дөр

Дугаар E/02

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА МИЕЭГОМБЫН ЭНХБОЛД ТАНАА


Элчин сайд нарыг эгүүлэн татах,
томилох асуудлаар зөвшилцөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсаас Швейцарийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ваанчигийн Пүрэвдорж, Бүгд Найрамдах Франц улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мундагбаатарын Батсайхан, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цолмонгийн Болор, Япон Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Содовжамцын Хүрэлбаатар, Америкийн нэгдсэн Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Булгаагийн Алтангэрэл, Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Раднаабазарын Алтангэрэл нарыг тус тус эгүүлэн татаж, Швейцарийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лүндэгийн Пүрэвсүрэн, Бүгд Найрамдах Франц улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Авиридиийн Баттөр, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамбын Ганбат, Япон Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Гончигзэвэгийн Тэнгэр, Америкийн нэгдсэн Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Ёндонгийн Отгонбаяр, Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Наваан-Юндэнгийн Чимгүүндарь нарыг тус тус томилох саналыг зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Холбогдох материалыг хавсаргав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

ЦАХИАГИЙН
ЭЛБЭГДОРЖ



0000000024